



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2025 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 327

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын филарманийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 12 нэрийн, нийт 40,177,590.00 (дөчин сая нэг зуун далан долоон мянга таван зуун ер) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 31,663,036.00 (гучин нэгэн сая зургаан зуун жаран гурван мянга гучин зургаа) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Улсын филарманийн захирал С.Баттулгад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ФИЛАРМОНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АШИГЛАХ ХУГАЦААГ СУНГАЖ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААН

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж балансын үнэ	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл	Шинэчлэн тогтоох нэг бүрийн үнэ	Шинэчлэн тогтоосон нийт үнэ	Цаашид ашиглах хугацаа /жил/
						(төгрөг)			
Машин, тоног төхөөрөмж									
1	Компьютер Dell A/O	2018-12-25	ширхэг	1	2,499,900	2,499,900.00	999,960.00	999,960.00	4
2	ASUS 15-8200 notebook	2019-09-27	ширхэг	1	1,540,000	1,540,000.00	616,000.00	616,000.00	4
3	Компьютер кор7-8700	2018-12-22	ширхэг	1	5,200,000	5,200,000.00	2,080,000.00	2,080,000.00	4
4	Принтер НРМ436DN	2019-07-01	ширхэг	1	2,049,990	2,049,990.00	819,996.00	819,996.00	4
5	Принтер samsung M2020	2018-12-25	ширхэг	1	144,700	144,700.00	57,880.00	57,880.00	4
6	Хар диск 1тв WS SSD	2019-09-12	ширхэг	1	412,500	412,500.00	165,000.00	165,000.00	4
7	Хар диск 2тв	2019-09-12	ширхэг	1	198,000	198,000.00	79,200.00	79,200.00	4
8	Жижиг бөмбөр ком	2018-10-01	ширхэг	1	1,800,000	1,800,000.00	900,000.00	900,000.00	6
9	Кислофон	2018-10-01	ширхэг	1	15,600,000	15,600,000.00	15,600,000.00	15,600,000.00	6
10	Их хуур	2018-10-01	ширхэг	1	4,887,500	4,887,500.00	4,500,000.00	4,500,000.00	6
11	Эвэр бүрээ	2018-10-01	ширхэг	1	4,025,000	4,025,000.00	4,025,000.00	4,025,000.00	6
12	Соло гитар	2017-10-28	ширхэг	1	1,820,000	1,820,000.00	1,820,000.00	1,820,000.00	6
	Машин, тоног төхөөрөмжийн дүн			12		40,177,590.00 (дөчин сая нэг зуун далан долоон мянга таван зуун ер)		31,663,036.00 (гучин нэгэн сая зургаан зуун жаран гурван мянга гучин зургаа)	